



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/99

Улаанбаатар хот

Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион
байгуулах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт, бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-н 2 дугаар хэсгийн 2.4.1, 2019 оны “Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай” А/285 дугаар захирамж, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2019 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр зохион байгуулах “Их цэвэрлэгээний 90 минут” арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, их цэвэрлэгээний ажлын нээлт, хаалтын арга хэмжээг зохион байгуулах, оролцогч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, нийслэлийн харьяа газар, агентлагуудын цэвэрлэгээ хийх хуваарь, их цэвэрлэгээний нэгдсэн удирдамжийг боловсруулж батлуулах, оролцогч бүх байгууллагуудад хүргүүлж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

2. “Их цэвэрлэгээний 90 минут” арга хэмжээг нэгэн зэрэг дүүрэг бүрт нэгдсэн удирдамжийн дагуу зохион байгуулах зорилгоор Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн цэвэрлэгээний ажилд хяналт тавьж ажиллахыг Инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/, Сонгинохайрхан дүүргийн цэвэрлэгээний ажилд хяналт тавьж ажиллахыг Аудит, дотоод хяналтын хэлтэс /Ц.Рэгээдмаа/, Хан-Уул, Баянгол дүүргийн цэвэрлэгээний ажилд хяналт тавьж ажиллахыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс /Б.Эрдэнэчимэг/, Баянзүрх дүүргийн цэвэрлэгээний ажилд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/ -т тус тус даалгасугай.

3. “Их цэвэрлэгээний 90 минут” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

4. Цэвэрлэгээний ажлыг зохион байгуулахад шаардагдах 16,480,000 /Арван зургаан сая дөрвөн зуун наян мянга/ төгрөгийг Иргэдийн бүлгийн цэвэрлэгээний зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.


УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



D:\backup_old_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

. 1110300314

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 04 сарын 11 өдрийн
АТ.95-7 тушаалын хавсралт



**“ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ 90 МИНУТ”
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын нэр	Нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт зардал
1	Хан-Уул дүүргийн 120 мянгантын гүүрэн гарцан дээр байршуулах сурталчилгаа хэвлүүлэх /21.7x2.7 хэмжээтэй 2 самбар/ +өлгөлт буулгалтын зардал	м.кв	120	7,000	840,000
2	Бээлий худалдан авах	ш	2500	500	1,250,000
3	Шуудай худалдан авах	ш	3000	350	1,050,000
4	Асар /3 x 3/	ш	3	120,000	360,000
5	Тайз /хөгжим, тайзны тоноглол, анонс орсон/	өдөр	1	2,000,000	2,000,000
6	УБЗАА-ны хэлтсүүд дүүргүүдэд хяналт тавихад шаардагдах шатахуун	талон	5	100,000	500,000
7	Постер хэвлүүлэх /А3/	ш	2000	330	660,000
8	Олон нийтэд мэдээлэл хүргэх /сошиал/				100,000
9	Хог тээвэрлүүлэх зардал	тн	200	48,600	9,720,000
Нийт					16,480,000